

ХОТГОЙДУУДЫН МАЛ АЖ АХУЙГАА ЭРХЛЭХ АРГА УХААНААС

Б.ЗОЛЖАРГАЛ

Нүүдлийн Соёл Иргэнийг Судлах Олон Улсын Хүрээлэн
e-mai Zolo_BD@yahoo.com

Түлхүүр үгс: Малын тарга тэвээрэг, “нар”, мал хариулга, бэлчээр

Өгүүллийн товч агуулга: Энэхүү өгүүлэлд Монгол орны баруун бүс нутагт орших Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох суманд амьдардаг Хотгойдууд мал маллагааны арга ажиллагаандаа нарны энергийг хэрхэн ашиглаж эрхэмлэдгийг харуулахыг зорилоо.

Хотгойдууд жилийн дөрвөн улиралд зохицуулан малыг хариулахдаа өвлийн улиралд малыг уулын нөмөр дулаан газраар бэлчээхээс гадна нар ургах үеэр малаа бэлчээж, орой нь нар жаргахаас өмнө хотлуулдаг. Мөн Цагаан сарын шинийн нэгний өдөр зориуд нөөцөлсөн бэлчээрт малаа хариулж, заавал хонь хургалуулдаг заншилтай байна.

Хаврын улиралд малд ашиг шимтэй газрыг сонгож маш нарийн зохион байгуулалттайгаар 2-3 удаа нүүж малаа төллүүлж, тарга хүчийг авхуулж эхлэдэг.

Зуны улиралд Хотгойдууд гол мөрөн лүүгээ зусаж, малаас гарсан ашиг шимийг нарны энергийг ашиглан боловсруулах бөгөөд малын тарга хүчийг авахуулдаг.

Намрын улиралд малын тарга хүчийг тогтоон хариулж, тарга хүч муу авсан малыг нарны илчийг ашиглан цусыг ханаж тарга хүчийг нь бүрэн авахуулдаг байна. Мөн цагаан идээ болон махан хүнсээ бэлтгэж авдаг. Эдгээр мал маллагааны арга ажиллагаанд нарны илч, эрчим хүчний ач холбогдол өгүүлжгүй их билээ.

Монгол улсын нутагт явуулсан археологийн судалгаанаас үзэхэд хүрэл зэвсгийн үед таван төрлийн малын сүргийн бүрдэл үүсэж, улмаар бэлчээрийн мал аж ахуй хөгжиж мал маллагааны сонгодог арга ажиллагаа үүсэн бүрэлдсэн байна. Тухайлбал: Монгол орны хангай, говийн байгалийн хаданд сийлсэн мал аж ахуйн сэдэвтэй зураг сүг маш олон байна (Окладников, 1981).

Монголын мал аж ахуй нь бэлчээрийн ургамалд түшиглэн өсөж үржиж байдаг тул монгол орны дөрвөн улиралд мал сүргээ цаг агаарын байдалд тохируулан төрөл бүрээр маш нарийн дэг журам мөрдөж ажилладаг уламжлалт арга ажиллагаанаас дурдвал:

Манай оронд нарны гийгүүлэх хугацаа нэг жилд ерөнхийдөө 2600-3300 цагийн хооронд хэлбэлздэг байна. Энэ бол нарны цацрагийн нөлөөнд монгол мал шууд ба шууд бус замаар байнга өртдөг. Нутгийн малд нарны хурц гэрэл аагим их халуун, их хүйтнээс хамгаалсан экологийн зохилдлогууд дасан зохицох урвал сайн хөгжсөн гэж эрдэмтэд үзсэн байна.

Манай оронд нар гийх хугацаа урт байдаг нь малын эрүүл ахуй болон өсөж торниход сайн нөлөөлдөг байна.

Бэлчээрийн мал аж ахуйтай манай орны хувьд нарны идэвхижлээс үүсэж гарах зүй тогтлыг нарийн судлан нарны идэвхижлийн өөрчлөлтийг урьдчилан тогтоож цаг агаарын бэрхшээл тохиолдож болохыг ажиглан мэдэж малын бэлчээр тэжээл, хашаа саравчаа урдаас сайн бэлтгэж байгаль цаг агаарын таагүй нөхцлөөс мал сүргийг хамгаалдаг (Төмөржав, 1989).

Монголчууд мал аж ахуйгаа эрхлэхдээ билгийн тооллын арван хоёр жилийг ашиглахаас гадна нарны эргэлтийг маш нарийн тооцоолж амьдрал ахуйдаа ашигладаг байна.

Хотгойдууд нь XVI зууны сүүл хагаст Халхад нэгдэн нийлсэн Ойрад гаралтай аймаг бөгөөд хожим тэд хэв заншил, хэл аялгууны хувьд бүрэн халхажсан, одоо өөрсдийгөө халхчууд гэж тооцдог ард түмэн юм (Нямбуу, 1992). Хотгойд ястан нь Монгол орны Хөвсгөл аймгийн Бүрэн, Тосонцэнгэл, Төмөрбулаг, Арбулаг, Бүрэнтогтох, Цэцэрлэг, Цагаан уул, Алаг-Эрдэнэ, Түнэл, Их уул сумдад, Завхан аймгийн Нөмрөг, Тэлмэн, Баян-уул, Баянхайрхан сумдад нутагладаг. Эдгээр сумдад нутаглаж буй хотгойдуудаас зөвхөн Бүрэнтогтох сумын хотгойдуудын мал маллагааны арга ажиллагааны “Нар”-тай уялдах зарим зүйлийг товч танилцуулж байна.

Хотгойдууд жилийн дөрвөн улиралд зохицуулан малаа хариулдаг. Үүнд:

Өвлийн улиралд: Өвлийн улиралд цаг агаар сайхан өдөр тал газруудаар малаа бэлчээдэг. Байгалийн байдал цас шуургатай үед уул, хад, мод бургастай нөмөр дулаан газраар бэлчээрлүүлдэг ба дотроо нарийн хуваарьтай байдаг. Жишээ нь: Цагаан сарын шинийн нэгний өдөр малаа бэлчээх өвс ургамал сайхантай нутгийг зориуд нөөцөлдөг. Энэ нөөцөлсөн газрыг ойр хавийн нутаг усныхан тодорхой мэддэг учраас малаа бэлчээдэггүй журамтай байсан байна. Уг бэлчээртээ цагаан сарын шинийн нэгний өглөө мал сүргээ (хонь, ямаа, үхэр) бэлчээж сайхан өвс ургамлыг идүүлдэг. Энэ нь мал сүргээ шинэлүүлж байгаа утгатай гэж хэлж болох юм. Энэ нөөцөлсөн уул усандаа бэлчсэн хонинуудаас шинийн нэгэнд хургалж байхаар хээлтүүлгийн ажлыг тохируулж хуцаа түр хугацаагаар тавьж 20-30 хонь хээлтүүлдэг бөгөөд шинийн нэгэнд заавал хонь хургалдаг. Шинийн нэгний өглөө хамгийн түрүүнд төллөсөн хонины хургыг буян хишигтэй мал гэж үзэх бөгөөд хурга нь эм буюу халзан цагаан хурга байвал хамгийн сайн гэж бэлэгшээж мал өснө гэж үздэг, харин эр хурга бол хуц тавьдаг байна. Тэр хургыг авахаар хүүхдүүд уралдан хэн түрүүлж очсонд нь өгдөг заншилтай.

Шинийн нэгний шөнө тэнгэр цэлмэг, одод гялалзаж байвал төл сайн хаваржин бат бөх байна гэж үздэг.

Өвлийн улиралд малыг бэлчээрт гаргах, хотлуулахдаа нарийн дэг журам баримталдаг байна. Адуу, тэмээ хоёрыг бараг хотлуулдаггүй. Бэлчээрт 4 цагийн улиралд өөрсдийн дураар идээшилж байдаг. Адууг өвлийн цагт зарим үед хашиж хонодог. Үүр цайх үед буюу нар мандахаас өмнөхөн бэлчээрт гаргадаг. Өвлийн цагт хол замд явсан хөлөрсөн мориныхоо эмээлийг нар жаргахаас өмнө авдаг бөгөөд нар жаргасан бол эмээлтэй буюу тохомтой нь хонуулдаг. Энэ нь хар сүүдэр цохиж өвчин тусна гэж болгоомжилдогтой холбоотой.

Хонь, ямаа, үхрийг өглөө нар ургах үеэр бэлчээрт гаргадаг. Учир нь үүнээс эрт малыг халуун хэвтрээс нь босгож хүйтэн жаварт гаргавал малын тарга хүчинд муугаар нөлөөлдөг байна. Нар жаргасны дараа хотон доторх малын

уулын сүүдэр эргэх үед хонио саана. Харин шинээр төллөсөн болон их сүүтэй хонь ямааг өглөө бэлчээрт гарахаас өмнө сааж сүү шимийг нь авч гурав саадаг байна. Үхрийг өглөө эрт нар гарахаас өмнө сааж сэрүүнд бэлчээдэг. Орой нь хонь ямааны дараа үхрээ саана.

Цагаан идээг боловсруулахад нар ихээхэн үүрэгтэй байдаг учраас түүнийг нарийн дэг журамтай тохируулдаг. Жишээ нь: Үхэр хонины сүүгээр өрөм байлгахад сүүгээ хөөрүүлж самраад нартай өдөр сүүдэр сэрүүн газар, бороотой сэрүүн үед дулаан газар тавих буюу хэтэрхий хөрсөн байвал гал дээр тавьж бүлээтгэж загсаана. Өрөм нь хонь, ямаа, үхрийн өрөм гэж байхаас гадна сүүгээ хөөрүүлээд самрахгүй гаргаж цөцгий загсааж авдаг байна. Хавар нь үхэр тугалласны дараа үхрийн өрөм иднэ, зун нь хонь ямааны өрөм, намар нь ямааны өрөм иддэг байна. Намар өвс гандаад ирэхээр цагаан төмстэй өрөм загсааж иддэг байна.

Малынхаа сүүгээр эзгийг ааруул хийхэд мөн нарны илчийг ашиглаж боловсруулдаг. Өглөө эрт сүүгээ эздүүлж эзгийг ааруулаа боловсруулж хонь, ямааны арьсан дээр дэлгэж хатаадаг. Харин нарны хор орно гээд үдийн их халуунд цагаан идээг хатаадаггүй сүүдэрт тавьдаг. Бас малынхаа өрмийг хурааж бог малын гүзээнд хийж гэрийн хаяанд тавьдаг. Нартай газар тавибал гашилдаг байна.

Бяслагийг шахаад хатаахдаа наранд тавьдаггүй, хөөж гашилдаг.

Гүүгээ сааж айраг исгэж уудаггүй. Харин зарим айл хөхүүртэй үхрийн сүүний айраг руу гүүний сүүг хийж бүлээд айраг исгэж архи нэрдэг. Үүнийг бэсрэглэнэ гэдэг. Зуны улиралд хураасан цагаан идээнээс хонины гүзээнд хураасан цагаан тосоо намрын адаг сарын шинийн 25 нд хайлж шар тос гаргаж, үлдсэн цөвөө эзгий, цөрөмтэй хольж хольсон тос болгодог. Энэ өдрийн нэг сонирхолтой зүйл бол эзгий, цөрөмтэй хольсон тосноос малын гүзээний хужирхайд хийж хүүхэд бүрт хувь болгон өгдөг байна.

Намрын улиралд: Судалгаанаас үзэхэд нутгийн монгол малын таргалах, биедээ өөх нөөцлөх чадвар нь уг малын биологи экологоор нөхцөлдсөн байдаг байна (Төмөржав, 1989).

Намрын цагт бүх мал тарга хүчээ авсан байдаг. Жишээ нь: Монгол хонины биенд намар тарга хүчээ гүйцэх үед 7-10 кг түүнээс илүү өөх хуримтлагддаг тул намрын мал маллагааны гол анхаарах зүйл нь малын тарга хүчийг тогтоох, хөлөргөж өөхөн таргыг хайлуулахгүй байхын тулд малчин нь малынхаа урд талд нь хорьж тогтоож хариулдаг байна. Адуу малыг өндөр уул, хавцал газар бэлчээхгүй, тал газар бэлчээж намарждаг байна.

Малын тарга хүчийг тогтоохдоо намрын шар нарыг их ашигладаг. Жишээ нь, нутаг сэлгэж нүүхийн өмнө ба шинэ нутагт буусны дараа ачлага уналгат хэрэглэх тэмээ, шарыг хэд хэдэн хоногоор уяж сойж тарга хүчийг тогтоодог байна. Намрын цагт адуун сүрэг сойлго алддаг учир хэд хэдэн удаа хашиж хонохоос гадна сойлго алдсан адууг өдрийн халуун наранд уяж хүчийг тогтоодог. Унагатай гүүг зориуд барьж өдрийн халуун наранд уяад орой нар шингэхээс өмнө бэлчээрт гаргана. Намар гүүг хээл хаяна гээд унадаггүй байна.

Намар цагт хонь, ямаан сүргээ тал газар ба уулын ар, нарны эсрэг сүүдэр газар тогтоож хариулдаг. Эр хонины өөхийг хайлуулж хүч таргыг алдуулахгүйн тулд ахрын ноосыг авдаг байна.

Монголчууд жилийн дөрвөн улиралд мал аж ахуй эрхлэхдээ байгаль газар зүйн байдал, тэнгэр эрхэс, нар сарны хөдөлгөөнд зохицуулж малаа

маллахаас гадна бас хүнс тэжээлээ бэлтгэхдээ цагаан идээний адил махан хүнсээ бэлтгэх малын амийг хороохдоо наранд улаа үзүүлэхгүй гэж хичээдэг заншилтай байжээ. Жишээ нь, малыг нар гарахаас өмнө өглөө эрт гаргадаг. Нөгөө талаар малыг хоттой хонины дэргэд гаргадаггүй мал жигшинэ гэдэг. Ялангуяа үхрийг гаргахдаа сэвс цусыг үхэрт харуулдаггүй заншилтай байна.

Өвлийнхөө хүнсийг бэлтгэхэд дунжаар 15-20 бог мал, 2 бод мал гаргаж махан хүнсээ бэлддэг байна. Хүнсээ бэлтгэсэн өдөр нарийн малын зүрхний хальсанд мах, сонгино, давс хийж амтлаад төрөл садныхаа хүүхдүүдэд хувь болгон өгдөг. Тэр мах чихсэн зүрхний хальсыг үнхэлцэг гэж нэрлэдэг байна.

Энэ бүхнээс үзэхэд монголчууд мал аж ахуйн үйл ажиллагаагаа “нар”-ны эргэлт, илч дулаан, жилийн дөрвөн улиралд нар мандах, жаргахтай нягт уялдуулан эрхлэн иржээ.

Хотгойдын уламжлалт мал маллагааны арга ажиллагаа, бэлчээрийн хуваарилалтад маш нарийн зохицуулалт хийн ашиглаж ирсэн уламжлал орхигдон мартагдаж байна.

НОМ ЗҮЙ

Нямбуу Х., 1992. Монголын угсаатны зүй.

Окладников А.П., 1981. Петроглифы монголии. Л.

Төмөржав М., 1989. Бэлчээрийн монгол мал. УБ.

SUMMARY

B.Zoljargal

ANIMAL HUSBANDRY PRACTICE OF KHOTGOID PEOPLE

In my paper, I have tried to introduce how Khotogoid people of Burentogtokh sum, Hovsgol aimag, Northern Mongolia, use the sun energy for their cattle-raising.

On the 1st day of a lunar New Year, herders lead their animals to the preserved pasture and have a tradition to give birth to the first lamb of the year.

In spring, they select high fertility grassland and move 2-3 times. It is time to produce young animals.

In summer, Khtgoid people camp near rivers and produce milk products using sun energy. Animals gain strength and fatness in summer.

If animals do not gain enough strength, herders bleed them. In autumn herders prepare meat and diary foods to use in winter and next year. Thus, the sun energy has a great importance for herders in animal-raising.